



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ивээлт Очир” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Д.Батзолбоо нь өөрийн эзэмшлийн нэг бүр нь 10,000.00 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,100 /хоёр мянга нэг зуу/ ширхэг, нийт 21'000'000.00 /хорин нэгэн сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг иргэн Д.Тэмүүлэнд шилжүүлсэн тул холбогдох өөрчлөлтийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ивээлт Очир” ХХК /Д.Батзолбоо/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



**“ИВЭЭЛТ ОЧИР” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ**

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьца аны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмий н санд эзлэх хувь	Хувьцаан ы тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцаан ы тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмий н санд эзлэх хувь
1	Д.Батзолбоо /ХГ79072170/	2,100	21,000,000.00	100%	(2,100)	-	21,000,000.00	-	-	-
2	Д.Тэмүүлэн /УХ92020235/	-	-	-	2,100	21,000,000.00	-	2,100	21,000,000.00	100%
	Нийт	2,100	21,000,000.00	100%	-	21,000,000.00	21,000,000.00	2,100	21,000,000.00	100%